



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/164

Мандалговь

Инженерийн хийцтэй худаг шинээр
барьж байгуулах ажил хүлээлцэх
ажлын комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах” багц-1 (Дэрэн сум, Луус сум, Өлзийт сум, Хулд сум) ажлын хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Ганчимэг (Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн аймгийн ажилтан)

Гишүүд: Б.Цэрэнсугир (Байгаль, орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Ж.Батхөлөг (Адаацаг сумын Засаг дарга)

Б.Түвшинбаатар (Сайхан-Овоо сумын Засаг дарга)

С.Мөнхбаатар (Эрдэнэдалай сумын Засаг дарга)

Д.Жаргалсайхан (“Грандхолдинг” ХХК-ийн захирал)

Хоёр. Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060684